

Хамтунгад

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Гавшгай ус" ААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/07/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.selenge@audit.gov.mn

Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040

Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036

Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом аудит" ХХК

Утас: 99052418

Цахим хаяг: reakomaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

СЭА-2023/07-НА-СТА-ОНА

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НБББББ	Нягтлан болох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮЭХ	Үйлдвэрчний эвлэлийн хороо
ХСУХАТАҮЗЗ	Хот суурин ус хангамжийн ариутгах татуурга ашиглалт үйлчилгээний зохицуулах зөвлөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3.Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	12
4. Аудитын тайлан	13
4.1. Ерөнхий зүйл.....	13
4.2. Материаллаг байдал.....	
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.3.1 Шилэн дансны мэдээлэл	14
4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
5.1 Запруулга	16
5.2 Төлбөрийн акт	
5.3 Албан шаардлага	17
5.4 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	19



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“ГАВШГАЙ УС”
ААТҮГ-ЫН ДАРГА
Б.ҮҮРДМӨНХ ТАНАА

2023.03.15 № СГА-2023/09 НЭСТА-ОКА
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Гавшгай ус” ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн нөлөөг эс тооцвол “Гавшгай ус” ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар бусдад хандив тусламж үзүүлсэн, жилийн эцэст эд хөрөнгийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, өр төлбөрийг тайлагналгүйгээр барагдуулсан, ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүйгээс цалин давхардуулан олгосон, зардлыг судалгаа тооцоон дээр үндэслэн бодитоор төлөвлөөгүйгээс батлагдсан зардлыг хэтрүүлсэн зэрэг зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1, 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

018020353

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд ажил, үйлчилгээний нийт орлогыг 1,606,975.6 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,751,106.4 мянган төгрөг төвлөрүүлэн, төлөвлөгөөг 9.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,843,564.7 мянган төгрөг болж төлөвлөснөөс 236,589.2 мянган төгрөг буюу 14.7 хувиар хэтэрч, 92,458.3 мянган төгрөгийн алдагдалтай тайлагнагдсан байна.

Аудитын гол асуудал

“Гавшгай ус” ААТҮГ нь Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газрын шийдвэрийн дагуу тайлант онд 6,168,452.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ангилал хооронд шилжүүлэн бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	1,651,644,396.0	1,837,067,551.6
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	58,623,347.6	75,670,153.6
1.1.2	Дансны авлага	1,315,207,379.5	1,501,484,537.5
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	3,546,225.9
1.1.6	Бараа материал	275,013,668.9	253,566,634.7
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	2,800,000.0	2,800,000.0
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,651,644,396.0	1,837,067,551.6
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	7,321,339,115.1	7,057,171,995.0
1.2.1	Үндсэн хөрөнгө	6,471,666,919.1	6,211,203,417.5
1.2.2	Биет бус хөрөнгө	849,672,196.0	845,968,577.5
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,321,339,115.1	7,057,171,995.0
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,972,983,511.1	8,894,239,546.6
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	1,733,052,322.8	1,746,766,721.0
2.1	ӨР ТӨЛБӨР	1,733,052,322.8	1,746,766,721.0
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	1,733,052,322.8	1,746,766,721.0
2.1.1.1	Дансны өглөг	224,190,437.4	110,438,749.0
2.1.1.2	Цалингийн өглөг	79,463,649.8	6,090,654.3
2.1.1.3	Татварын өр	526,392,585.5	634,450,941.1
2.1.1.4	НДШ-ийн өглөг	901,054,450.1	993,835,176.6
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	1,951,200.0	1,951,200.0
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,733,052,322.8	1,746,766,721.0
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,733,052,322.8	1,746,766,721.0
2.3.1	Төрийн өмч	294,374,941.7	294,374,941.7
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,296,382,891.4	7,296,382,891.4
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,556,423,439.0	1,556,423,439.0
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,907,250,083.8)	(1,999,708,446.4)
2.3.11	Эздийн өмчийн дүн	7,239,931,188.3	7,147,472,825.6
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	8,972,983,511.1	8,894,239,546.6

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,426,804,303.0	1,732,492,549.4
2	Борлуулалтын өртөг	1,580,141,595.8	1,628,460,232.1
3	Нийт ашиг (алдагдал)	(153,337,292.8)	104,032,317.3
8	Бусад орлого	14,405,001.0	18,613,896.6
10	Ерөнхий ба удирдлагын зардал	60,321,803.3	146,687,963.9
12	Бусад зардал	53,509,693.2	68,416,612.6
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(99,426,495.5)	(92,458,362.6)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(252,763,788.4)	(92,458,362.6)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(252,763,788.4)	(92,458,362.6)
24	Орлогын нийт дүн	(252,763,788.4)	(92,458,362.6)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/						
	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-
6	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
9	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	294,374,941.7	7,296,382,891.4	1,556,423,439.0	(1,907,250,083.8)	7,239,931,188.3
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	294,374,941.7	7,296,382,891.4	1,556,423,439.0	(1,907,250,083.8)	7,239,931,188.3
12	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
13	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(92,458,362.6)	(92,458,362.6)
14	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
17	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	294,374,941.7	7,296,382,891.4	1,556,423,439.0	(1,999,708,446.4)	7,147,472,825.6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,426,804,303.0	1,468,036,437.3
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	1,411,796,004.4	1,458,036,437.3
1.1.6	Бусад мөнгөн орлого	-	10,000,000.0
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,355,835,904.1	1,422,509,631.4
1.2.1	Ажиллагчдад төлсөн	522,720,695.1	661,189,377.1
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	256,493,642.0	90,753,643.0
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	192,072,598.5	66,108,609.0
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	31,242,531.7	317,240,266.4
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	73,894,395.2	109,505,252.8
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	4,444,106.7	2,933,545.5
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,534,555.0	135,532,728.7
1.2.9	Бусад мөнгөн зарлага	21,512,379.1	39,246,208.9
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	55,960,100.3	45,526,806.0
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	28,480,000.0
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	23,230,000.0	28,480,000.0
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	11,121,000.0	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	34,351,000.0	(28,480,000.0)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	55,960,100.3	17,046,806.0
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,663,247.3	58,623,347.6
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	58,623,347.6	75,670,153.6

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны		Зөрүү	Хувь
			төлөвлөгөө	гүйцэтгэл		
1	ОРЛОГЫН ДҮН	м/төг	1,606,975.6	1,751,106.4	(144,130.8)	109.0
	Үйл ажиллагааны орлого	м/төг	1,600,975.6	1,722,492.6	(121,517.0)	107.6
	Татаас санхүүжилт	м/төг		10,000.0	(10,000.0)	
	Бусад орлого	м/төг	6,000.0	18,613.8	(12,613.8)	310.2
2	ЗАРЛАГА ДҮН	м/төг	1,606,975.6	1,843,564.7	(236,589.1)	114.7
1	ЦАЛИН	м/төг	685,624.8	705,476.6	(19,851.8)	102.9
2	НД-ийн шимтгэл	м/төг	99,775.6	102,532.5	(2,756.9)	102.8
3	ҮХ элэгдэл	м/төг	43,841.4	285,636.8	(241,795.4)	651.5
4	Цахилгаан	м/төг	304,713.8	315,381.4	(10,667.6)	103.5
5	Үндсэн хөрөнгө худалдан авах	м/төг	80,000.0	51,566.7	28,433.3	64.5
6	Шатахуун	м/төг	41,782.5	44,829.5	(3,047.0)	107.3
7	Дулаан	м/төг	32,759.9	22,848.0	9,911.9	69.7
8	Хөдөлмөр хамгаалал, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал	м/төг	34,614.1	34,568.2	45.9	99.9
9	Тэтгэмж, тусламжийн зардал	м/төг	25,000.0	24,176.7	823.3	96.7
10	Нүүрс	м/төг	70,513.5	69,035.4	1,478.1	97.9
11	Холбоо	м/төг	4,200.0	4,116.0	84.0	98.0
12	Сургалт	м/төг	1,000.0	810.0	190.0	81.0
13	Томилолт	м/төг	4,300.0	4,235.8	64.2	98.5
14	Тээврийн хэрэгслийн татвар	м/төг	1,600.0	1,571.7	28.3	98.2
15	Зохицуулах үйлчилгээний хөлс	м/төг	6,000.0	5,200.0	800.0	86.7
16	НӨАТ, ХАОАТ, суутган	м/төг	77,000.0	74,040.1	2,959.9	96.2
17	Ус ашигласны татвар	м/төг			-	
18	Урсгал засвар	м/төг	74,000.0	63,504.6	10,495.4	85.8
19	Программ хангамжийн зардал	м/төг			-	
20	Аудитын зардал	м/төг			-	
21	Даатгал	м/төг	250.0	244.8	5.2	97.9
22	Хүү торгуулийн зардал	м/төг	20,000.0	33,789.9	(13,789.9)	168.9
23	Харуул хамгаалалтын зардал	м/төг			-	
24	Бусад зардал	м/төг			-	
3	Үйл ажиллагааны ашиг алдагдал (1-2)	м/төг	-	(92,458.3)	92,458.3	
4	Орлогын татвар (3*10%)	м/төг			-	
5	ЦЭВЭР АШИГ, АЛДАГДАЛ (3-4)	м/төг	-	(92,458.3)		

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Гавшгай ус” ААТҮГ нь “Хөтөл тосгоны ард иргэд, аж ахуйн нэгжийг унд, ахуйн цэвэр усаар тасралтгүй, найдвартай хангах” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Гавшгай ус” ААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Усан хангамж, ариутгах татуурга,
- Ус цэгийн засвар, өрөмдлөгийн ажил,
- Барилга байгууламжийн засвар үйлчилгээ, гражийн барилга байгууламж,
- Усны хайгуул, судалгаа,
- Халуун ус, саун,
- Гадаад худалдаа гэх мэт.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар” гэж заасан буюу 100 хувь орон нутгийн өмчийн эзэмшилд байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Гавшгай Ус” ААТҮГ нь аймгийн ИТХ-ын 2005 оны 78 дугаар тогтоолоор “Гавшгай ус” ХХК нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 80 дугаар тогтоолоор “Гавшгай ус” ААТҮГ болон өөрчлөгдсөн байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-д “Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно”, 21 дүгээр зүйл “Аймгийн чиг үүрэг”, 21 дүгээр зүйлийн 21.1.15 дахь “харилцаа холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн гэх мэт.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Гавшгай ус” ААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

“Гавшгай ус” ААТҮГ нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч аж ахуйн тооцоот зарчмаар ажилладаг байгууллагын онцлогт тохироогүй, борлуулалтын орлого, өртгийн тооцоолол, татаас санхүүжилт, хөрөнгө оруулалтын талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Гавшгай ус” ААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	58,623.3	75,670.2	17,046.9
Авлага	1,315,207.4	1,501,484.5	186,277.1
Татвар, НДШ-ийн авлага		3,546.2	3,546.2
Урьдчилж төлсөн зардал	2,800.0	2,800.0	0.0
Бараа материал	275,013.7	253,566.6	-21,447.1
Үндсэн хөрөнгө	7,321,339.1	7,057,172.0	-264,167.1
Нийт хөрөнгийн дүн	8,972,983.5	8,894,239.5	-78,744.0
Өр төлбөр	1,733,052.3	1,746,766.7	13,714.4
Эздийн өмч	7,239,931.2	7,147,472.8	-92,458.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө амчийн дүн	8,972,983.5	8,894,239.5	-78,744.0

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 17,046.9 мянган төгрөгөөр өссөн нь 1,468,036.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,450,989.5 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 1,501,484.5 мянган төгрөг болж 186,277.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь оршин суугчдаас авах авлага өссөнөөс шалтгаалсан байна.

Татвар, НДШ-ийн авлагын 3,546.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь төлбөр тооцоог хянаагүйн улмаас буюу нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас тайлант онд шинээр үүссэн авлагаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 253,566.6 мянган төгрөг болж 21,447.1 мянган төгрөгөөр буурсан нь 301,676.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 323,124.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 73,216.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр 51,021.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 545.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан, хувь хүнээс авах авлагад тооцож 21,650.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэсэн, Сэлэнгэ аймгийн ОНӨГ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 459 дугаар албан бичгээр 6,168,452.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ангилал хооронд шилжүүлэн бүртгэсэн зэргээс шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,746,766.7 мянган төгрөг болж 13,714.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь татварын болон нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийн өсөлтөөс голлон шалтгаалжээ.

Эздийн өмч дансны үлдэгдэл 7,147,472.8 мянган төгрөг болж 92,458.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Гавшгай ус” ААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн А/264 дугаар захирамжаар “Гавшгай ус” ААТҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 1,606,975.6 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,606,975.6 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 1,751,106.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,843,564.7 мянган төгрөгийн зардал гарган, 92,458.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлого 1,751,106.4 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдан, төлөвлөгөөг 144.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, 109.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,843,564.7 мянган төгрөг болж төлөвлөснөөс 236,589.2 мянган төгрөг буюу 14.7 хувиар хэтэрч, 92,458.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь ажил үйлчилгээ, сэлбэг материалын үнийн өсөлт, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал зэргээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Гавшгай ус” ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өгсөн санхүүгийн тайлангийн тодруулга бэлтгэхтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг, аудиторын туслах Б.Улам-Оргил нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Гавшгай ус” ААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайланг “Пийк Ом Аудит” ХХК-д 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 64 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,693,973.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 16,939.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах, албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн боловч бүрэн хэрэгжүүлээгүйгээс тайлант хугацаанд мэдээлбэл зохих 17 төрлийн 228 мэдээллээс 71 мэдээллийг хугацаа хоцроож, 76 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнд:

- Төсөв гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг 33 удаа хугацаа хоцроож, 18 удаа огт мэдээлээгүй,
- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг 18 удаа хугацаа хоцроож, 31 удаа огт мэдээлээгүй,
- Бусад мэдээллийг 20 удаа хугацаа хоцроож, 27 удаа огт мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй.....бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн холбогдох албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд аймгийн ОНӨГ-ын 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 105 дугаар албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн үндсэн үйл ажиллагаатай шууд холбоогүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх, тээвэр шатахуун, шуудан холбооны зардлыг хэмнэх, 2021 оны санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн өглөг, авлагыг бууруулах зөвлөмжүүдийг, аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн 01/1696 албан бичгээр Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж сум, орон нутгийн төр төсвийн байгууллага, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудыг төсвийн хөрөнгөөр “Шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулахгүй” байх чиглэл хүргүүлсэн байна.

“Гавшгай ус” ААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Үндсэн хөрөнгө худалдан авах зардлыг 28,433.3 мянган төгрөгөөр хэмнэсэн,
- Халаалт, дулааны зардлыг 9,911.9 мянган төгрөгөөр хэмнэсэн,
- Түүхий эд нүүрс, урсгал засварын зардлыг 11,973.5 мянган төгрөгөөр
- Олон жилийн насжилттай авлагыг бууруулах ажлыг зохион байгуулснаар 36,400.9 мянган төгрөгийн авлагыг төвлөрүүлсэн,
- Хандив тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх, өөрийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл болон согтууруулах ундаа худалдан авахыг хориглох зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажилласан байна.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом Аудит” ХХК-ийн 2022 оны 11 дүгээр 09-ны өдрийн 194 дүгээр албан бичгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 2,997.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 1,290.1 мянган төгрөгийн тэтгэмж олгосон, төлөвлөгөөнд тусгагдаагүй 19,800.0 мянган төгрөгийн үндсэн худалдан авсан зэрэг зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлагыг биелүүлж, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	2,997.0	1	2,997.0	100.0
Албан шаардлага	2	1,290.1	1	1,290.1	50.0
Зөвлөмж	1	19,800.0	1	19,800.0	100.0
Нийт дүн	4	24,087.1	3	24,087.1	75.0

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

4.6.1. Үйлдвэрийн газрын нягтлан бодогчдын мэдлэг, ур чадвар хангалтгүй, санхүүгийн программ хангамжийг ашиглах чадвар сул байгааг анхаарч тэдний мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, хариуцлагыг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

4.6.2. Тус байгууллага нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч аж ахуйн тооцоот зарчмаар ажилладаг үйлдвэрийн газрын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй учир өөрийн онцлогт тохирсон НБББББ-ыг боловсруулан мөрдөх нь зүйтэй юм.

5. Аудитын илрүүлэлт

5.1 Залруулга

Аудитаар нийт 135,075.7 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд эдийн засгийн ангилал хооронд шилжүүлсэн 3,464.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг орлогоор тусгаагүйгээс үндсэн хөрөнгийн үлдэгдлийг зөрүүтэй илэрхийлсэн,
- Бараа материалын тодруулга тайланд хангамжийн материалын 108,525.0 мянган төгрөгийн орлого зарлагыг тусгаагүйгээс бараа материалын эцсийн үлдэгдэл зөрүүтэй тайлагнагдсан,
- Мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан үндсэн хөрөнгийг 23,086.7 мянган төгрөгөөр дутуу тусгасан,

Аудитаар нийт 37,808.0 мянган төгрөгийн зөрчил илэрч, 182.8 мянган төгрөгийн төлбөрийн акт, 37,625.2 мянган төгрөгийн албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Сайхан суманд албан томилолтоор ажилласан Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга Б.Дарихжавын зочид буудлын хөлс, хоолны зардалд 182.8 мянган төгрөг төлж, хандив тусламж үзүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 дахь “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. 2022 оны санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслэн тооцож, төлөвлөн батлуулаагүйгээс цалин шимтгэлийн зардлыг 22,608.7 мянган төгрөгөөр, шатахууны зардлыг 3,047.0 мянган төгрөгөөр зэрэг нийт 25,655.7 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан **биелэлтийг хангах**” гэсэн заалт болон аймгийн Засаг даргын баталсан “Гавшгай ус” ААТҮГ-ын 2022 оны санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөө”-г зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тухайн жилийн санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөж, мөрдөн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. 2022 оны жилийн эцэст эд хөрөнгийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ” 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө, 20 дугаар зүйлийн 20.2.6. дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг хууль тогтоомжийн дагуу үнэн зөв хийж гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэх.

3. Тайлант онд нэр бүхий 39 албан тушаалтны ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүй гэх үндэслэлээр ажилласан хугацааны цалин 10,839.7 мянган төгрөгийг ээлжийн амралтын цалинтай давхардуулан олгосон нь үйлдвэрлэлийн үр дүнд сөргөөр нөлөөлсөн байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т

заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдыг биеэр нөхөн амруулж, цалингийн давхардал үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

4. 2021 оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр Д.Цэнд-Аюушийн нийгмийн даатгалын сангаас олгох ёстой ажилгүйдлийн тэтгэмжид 1,129.8 мянган төгрөгийг олгож, тайлант оны зардлаар бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.3: “бүх өр төлбөр”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгасны үндсэн дээр барагдуулж байх албан шаардлага хүргүүлэх.

5.4 Зөвлөмж

1. Санхүүгийн тайлангийн тодруулгатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1. “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 8.1.5. “санхүүгийн тайлангийн тодруулга” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгыг иж бүрэн хийж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИГ ЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлангийн тодруулга тайланд эдийн засгийн ангилал хооронд шилжүүлсэн хөрөнгийг орлогоор тусгаагүй	1	3,464.0			1	3,464.0	1	3,464.0				
Санхүүгийн тайлангийн тодруулга тайланд хангамжийн материалын орлого, зарлагыг дутуу илэрхийлсэн	1	108,525.0			1	108,525.0	1	108,525.0				
Мөнгөн гүйлгээний тайланд шинээр худалдаж авсан хөрөнгийг	1	23,086.7			1	23,086.7	1	23,086.7				
Дүн	3	135,075.7			3	135,075.7	3	135,075.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ээлжийн амралтыг биеэр эдлүүлэлгүйгээр цалин давхардуулан олгосон	1	10,839.7			1	10,839.7						
Бусдад хандив тусламж олгосон	1	182.8	1	182.8								
Батлагдсан зардлыг хэтрүүлсэн	1	25,655.7			1	25,655.7						
Өр төлбөр үүсгэлгүйгээр 2021 онд олгох ёстой ажилгүйдлийн тэтгэмж олгосон	1	1,129.8			1	1,129.8						
Санхүүгийн тайлангийн тодруулга хийгээгүй	1						1					

Дүн	5	37,808.0	1	182.8	3	37,625.2	1				
-----	---	----------	---	-------	---	----------	---	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбосотой зөрчил								
Мэдээлэл хоцроосон	71				71			
Огт мэдээлээгүй	76				76			
Дүн	147				147			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								